24	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,000,000.00	10,000,000.00	10,000,000.00	
25	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	510,000.00	510,000.00	510,000.00	
26	Нормативт зардал	150,000.00	150,000.00	150,000.00	
27	Нормын хувцас, зөөлөн эдлэл	150,000.00	150,000.00	150,000.00	
28	Эд хогшил, урсгал засварын зардал	14,360,300.00	14,351,300.00	14,351,300.00	

**Баруунбаян-Улаан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

29	Багаж, техник, хэрэгсэл	1,400,000.00	1,400,000.00	1,400,000.00	
30	Урсгал засвар	12,960,300.00	12,951,300.00	12,951,300.00	
31	Томилолт, зочны зардал	6,617,100.00	6,616,690.00	6,616,690.00	
32	Дотоод албан томилолт	6,617,100.00	6,616,690.00	6,616,690.00	
33	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,899,000.00	23,818,250.00	23,818,250.00	
34	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,880,000.00	16,880,000.00	16,880,000.00	
35	Тээврийн хэрэгслийн татвар	220,000.00	140,100.00	140,100.00	
36	Тээврийн хэрэгслийн оношилгоо	84,000.00	84,000.00	84,000.00	
37	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,450,000.00	6,449,150.00	6,449,150.00	
38	Газрын төлбөр	265,000.00	265,000.00	265,000.00	
39	Бараа үйлчилгээний бусад зардал	73,059,300.00	52,587,716.00	48,053,125.00	34,654,591.00
40	Бараа үйлчилгээний бусад зардал	69,389,300.00	48,917,716.00	48,917,716.00	30,070,000.00
41	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,670,000.00	3,670,000.00	3,670,000.00	50,000.00
42	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,138,900.00	32,701,200.00	32,701,200.00	
43	Бусад урсгал шилжүүлэг	64,138,900.00	32,701,200.00	32,701,200.00	
44	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,368,600.00	8,368,600.00	8,368,600.00	
45	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	55,430,300.00	23,992,600.00	23,992,600.00	
46	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	340,000.00	340,000.00	340,000.00	
47	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	329,962,800.00	248,741,455.00		248,741,455.00
48	Бусад хөрөнгө	329,962,800.00	248,741,455.00	248,741,455.00	
49	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	184,444,600.00	97,440,530.00		97,440,530.00
50	Эргэж төлөгдөх зээл	184,444,600.00	97,440,530.00	97,440,530.00	
51	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,382,672,000.00	1,122,480,798.05	805,053,720.05	317,427,078.00
52	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ			803,414,330.70	-
53	Улсын төсвөөс санхүүжих			803,414,330.70	-
54	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,024,994,300.00	988,266,746.05		988,266,746.05
55	Орон нутгийн төсвөөс	841,403,300.00	804,675,720.05		804,675,720.05
56	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	183,591,000.00	183,591,026.00	183,591,026.00	
57	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	357,677,700.00	134,214,052.00	1,639,389.35	132,574,662.65
58	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	132,126,200.00	129,787,157.00	99,161,957.00	30,625,200.00
59	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,972,000.00	4,426,895.00	4,426,895.00	
60	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	200,579,500.00		200,579,688.15	-
61	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		169,546,218.80		168,693,098.80
62	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		135,403,600.80		135,403,600.80
63	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	88.00	52.00		52.00
64	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00		2.00
65	Төсвийн байгууллага	2.00	2.00		2.00
66	АЖИЛЛАГСАДЫН ТОО	43.00	25.00		25.00
67	Удирдах ажилтан	8.00	8.00		8.00
68	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00		8.00
69	Үйлчлэх ажилтан	3.00	4.00		4.00
70	Гэрээт ажилтан	24.00	5.00		5.00
71	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	43.00	25.00		25.00
72	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	9.00		9.00
73	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3.00	4.00		4.00

**Баруунбаян-Улаан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

74	Гэрээт ажилтан	24.00	4.00		4.00
75	Улс төрийн албан хаагч (УТ)	7.00	8.00		8.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Тайлант оны гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	76,170,100.00
2	УРСГАЛ ЗАРДАЛ	20,170,100.00
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,170,100.00
4	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,350,000.00
5	Цэвэр, бохир ус	1,350,000.00
6	Эд хогшил, урсгал засварын зардал	5,745,000.00
7	Урсгал засвар	5,745,000.00
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,075,100.00
9	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,075,100.00
10	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	56,000,000.00
11	Эргэж төлөгдөх зээл	56,000,000.00
12	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	76,170,100.00
13	Нэмэлт санхүүжилтийн орлого	76,170,100.00
14	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	76,170,100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сумын санхүүгийн алба нь Төсвийн тухай хуульд заасан чиг үүргийн дагуу төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, ажил гүйлгээг хянах, ажил гүйлгээг батлах чиг үүргийг гүйцэтгэдэг.

Санхүүгийн албанд дарга-1, мэргэжилтэн-1, нягтлан бодогч -3 нийт 5 орон тоотой ажиллаж байна. Тус суманд төсөвт байгууллага-6, орон нутгийн сан-3 үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1."Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно." гэж заасан.

Мөн хуулийн 36.1."Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогч /цаашид "төрийн сан" гэх/-оос бүрдэнэ.

36.2.Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна.

36.3.Сум, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон төсвийн хэмжээг нь харгалзан төрөлжүүлж, тэдгээрт хамаарах төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн алба байгуулж болно." гэсэн заалтуудаар зохицуулагдаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баруунбаян-Улаан сумын Төрийн сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт

Баруунбаян-Улаан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,448.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	201.4	138.9	-62.5
Авлага	140.5	173.3	32.8
Бараа материал	261.0	34.4	-226.6
Үндсэн хөрөнгө	3,492.6	1,310.9	-2,181.7
Нийт хөрөнгө	4,113.1	1,664.7	-2,448.4
Өр төлбөр	49.9	17.0	-32.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,063.2	1,647.7	-2,415.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,113.1	1,664.7	-2,448.4

Тайлант онд сумын ОНХСанд 27.2 сая төгрөг, СХСанд 142.3 сая төгрөгийн авлага нэмэгдэж, ЭМТөвийн авлага 48.2 сая төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын үлдэгдэл 226.6 сая төгрөгөөр буурсан нь боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагуудын бараа материалын эхний үлдэгдлийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 2,181.7 сая төгрөгөөр буурсан нь мөн боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагуудын үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэнтэй холбоотой байна.

Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 138.9 сая төгрөг болж, өмнөх оноос 62.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	0	0	
Банканд байгаа бэлэн мөнгө	201.4	138.9	-62.5
Төгрөг			
Төрийн сангийн харилцах	201.4	138.9	-62.5
Арилжааны банк дахь харилцах			
Дүн	201.4	138.9	-62.5

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь төрийн сангийн харилцах дансанд үлдэгдэлтэй байна. СХСан, ЭХСан ОНӨОрлого, ОНХСан зэрэг байгууллагууд мөнгөн хөрөнгийг үлдэгдэлтэй гарчээ.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 173.3 сая төгрөг болж, өмнөх оноос 32.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	4.0		-4.0
Зээлийн хүүгийн авлага	5.4	5.4	0
Төлбөртэй үйлчилгээний авлага	47.0		-47.0
Хувь хүмүүсээс авах авлага	84.1	167.9	83.8
Дүн	140.5	173.3	32.8

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны нийт авлагыг зээлийн хүүгийн авлага, байгууллагаас авах авлага, хувь хүмүүсээс авах авлага эзэлж байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 34.4 сая төгрөг болж, өмнөх оноос 226.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	70.7		-70.7
Хангамжийн материал	181.6	15.7	-165.9
Мал амьтад	8.7	18.7	10
Дүн	261.0	34.4	-226.6

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 226.6 сая төгрөгөөр буурсан нь боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагуудын бараа материалын эхний үлдэгдлийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

3.4.4 Мал амьтад

Мал амьтад 10.0 сая төгрөгөөр өссөн байна.

3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,310.9 сая төгрөг болж,

өмнөх оноос 2,181.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	3,416.8	1,296.3	-2,120.5
Барилга, байгууламж, орон сууц	2,798.9	790.7	-2,008.2
Хуримтлагдсан элэгдэл	-327.0	-144.1	182.9
Авто-тээврийн хэрэгсэл	422.4	277.8	-144.6
Хуримтлагдсан элэгдэл	-217.4	-166.6	50.8
Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,106.1	358.9	-747.2
Хуримтлагдсан элэгдэл	-799.3	-275.3	524.0
Тавилга, аж ахуйн эд хогшил	115.0	40.3	-74.7
Хуримтлагдсан элэгдэл	-67.7	-28.7	39
Зам, гүүрийн байгууламж	64.0	43.5	-20.5
Хуримтлагдсан элэгдэл	-17.7	-6.5	11.2
Бусад үндсэн хөрөнгө	473.8	601.6	127.8
Хуримтлагдсан элэгдэл	-172.5	-195.4	-22.9
Ном	38.2	0.05	-38.1
Биет бус хөрөнгө	75.8	14.7	-61.1
Программ хангамж	2.2	0.6	-1.6
Хуримтлагдсан элэгдэл	-1.9	-0.6	1.3
Бусад биет бус хөрөнгө	75.5	14.7	-60.8
Дүн	3,492.6	1,310.9	-2,181.7

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 2,181.7 сая төгрөгөөр буурсан нь боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагуудын үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэнтэй холбоотой.

Сумын ЗДТГ, ИТХ зэрэг байгууллагууд 239.3 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэлд тусгажээ.

3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 17.0 төгрөг болж, өмнөх оноос 32.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	23.0	2.0	-21.0
Бараа үйлчилгээний зардлын өглөг	26.9		-26.9
Байгууллагад төлөх өглөг		15.0	15.0
Дүн	49.9	17.0	-32.9

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

ЭМТөвийн өмнөх оны өглөг 46.9 сая төгрөг, ЕБС-ийн өглөг 1.5 сая төгрөг, ЗДТГ-ын өглөг 0.9 сая төгрөгөөр тус тус буурсан байна. ИТХ-ын ажилчидтай холбогдсон өглөг 1.5 сая төгрөг, ОНӨО-ын байгууллагад өгөх өглөг 15.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,647.6 сая төгрөг болж, өмнөх оноос 2,415.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан			
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,757.0	810.9	-946.1
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/			
Хуримтлагдсан үр дүн	1,448.2	514.6	-933.6
Өмнөх үеийн үр дүн	1,337.6	2,926.8	1,589.2
Тайлант үеийн үр дүн	110.6	-2,412.2	-2,522.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	857.9	322.1	-535.8
Дүн	4,063.1	1,647.6	-2,415.5

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмчийн дүн буурсан нь улсын төсвийн байгууллагуудын хөрөнгийн эхний үлдэгдлийг зардалд хааснаас тайлант оны үр дүн буурсантай холбоотой.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сумын ИТХ-ын 2021 оны 5/02 тоот тогтоолоор 2022 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,520.5 сая төгрөгөөр баталжээ.

Сумын 2022 оны төсөвт тодотгол хийх тухай 2022 оны 07/01 тогтоолоор төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,382,7 сая төгрөг болгон бууруулж баталсан байна. Энэ нь аймгаас олгох санхүүгийн дэмжлэг 74,8 сая төгрөгөөр хасагдсантай холбоотой.

Сумын төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг 290.2 сая төгрөгөөр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогын гүйцэтгэл 235.2 сая төгрөг буюу 18.9 хувиар дутуу биелжээ.

Хүснэгт-9

төгрөгөөр

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Хүн амын орлогын абан татвар	13,000,000.00	11,149,849.03	(1,850,150.97)	85.77%
2	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	2,000,000.00	3,265,092.96	1,265,092.96	163.25%
3	Галт зэвсгийн албан татвар	1,300,000.00	1,050,000.00	(250,000.00)	80.77%
4	Улсын тэмдэгтийн хураамж	1,190,300.00	951,180.00	(239,120.00)	79.91%
5	Газрын төлбөр	3,200,000.00	3,419,390.00	219,390.00	106.86%
6	Ус.Рашаан ашигласны төлбөр	1,700,000.00	-	(1,700,000.00)	0.00%
7	ХХОАТ	113,306,300.00	135,030,845.55	21,724,545.55	119.17%
8	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	7,000,000.00	6,330,836.48	(669,163.52)	90.44%
9	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,000,000.00	500,000.00	(500,000.00)	50.00%
10	Мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	54,500,000.00	26,176,203.91	(28,323,796.09)	48.03%
11	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	99,677,400.00	60,771,260.00	(38,906,140.00)	60.97%

**Баруунбаян-Улаан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

12	Хөрөнгө борлуулсны орлого	200,000.00	50,268.00	(149,732.00)	25.13%
13	Нохойны албан татвар	300,000.00	-	(300,000.00)	0.00%
14	Татварын буцаан олголт	(13,459,800.00)	(13,459,815.90)	(15.90)	100.00%
	Татварын орлого	284,914,200.00	235,235,110.03	(49,679,089.97)	82.56%
1	Татварын бус /Хүү, торгуулийн орлого	5,300,000.00	5,640,000.00	340,000.00	106.42%
	Нийт дүн	290,214,200.00	235,235,110.03	(54,979,089.97)	81.06%

Татварын орлогын төлөвлөгөө 18.9 хувиар тасарч биелсэн нь хөрөнгө борлуулсны орлого, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого, мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого, ус рашаан ашигласны орлогууд тус тус биелэгдээгүй байна.

ХХОАТ, ҮХХАТатвар, хөрөнгө борлуулсны орлого давсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар 76.2 сая төгрөгийн санхүүжилт авч, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, эд хогшил, урсгал засварын зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баруунбаян-Улаан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор Р.Цэрэндолгор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын захирал, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруунбаян-Улаан сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 1/34 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг 75 хувь гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын дүн 958.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 14.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор суманд олгох санхүүгийн дэмжлэг буурч, төсөвтөө хасах тодотгол хийсэн ба тэр хэмжээгээр холбогдох зардлууд хэмнэгдсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баруунбаян-Улаан сумын ТТЗ нь 2022 онд 155 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 154 мэдээллийг ил тод мэдээлсэн, 1 мэдээллийн хугацаа болоогүй байна.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын хувьд бусад нийцлийн асуудлын талаарх хамааралтай асуудал байхгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар ТТЗ-тай холбоотой зөрчил илрээгүй.

Хүснэгт 10. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж					
Нийт дүн					

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж, тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардлаас бусад зардалд төсвийн хөрөнгийг зарцуулахгүй байх

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 2 зөрчил¹ илэрч, 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Тус байгууллага дээр акт гараагүй.

5.2 Албан шаардлага

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цаглаварт хугацаанд аудит хийлгээгүй, хугацаа хоцорсон.

Илрүүлэлт:

Тус сумын цэцэрлэг нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон жилийн эцсийн санхүүгийн тайландаа Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цаглаварт хугацаанд аудит хийлгээгүй, хугацаа хоцорсон.

Шийдвэрлэлт:

Баруунбаян-Улаан сумын цэцэрлэгийн эрхлэгч Ц.Март, нягтлан бодогч Н.Мөнхжаргал нарт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт албан тоотоор ирүүлэх

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шийдвэр гаргалт, үйл ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сумдын төсөвт байгууллагуудын дарга нарт ур чадварын нэмэгдэл олгохдоо ажлын үр дүнтэй уялдуулж хувь хэмжээг тогтоож, тухай бүр шийдвэр гаргаагүй, бүтэн жилээр тогтмол олгож ирсэн байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын удирдлагуудын ур чадварын нэмэгдлийг улирал тутам ажлын үр дүнгийн үзүүлэлттэй уялдуулан тухай бүр тогтоож олгох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ТТЗ-ийн харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийн талаар

Аудитад хамрагдсан 4 байгууллага түүвэрт хамруулсан./ ЗДТГ, ИТХ, ОНХСан, СХСан/

Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэлээр 94.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 7 албан шаардлага, 1 акт, 3 зөвлөмж хүргүүлсэн байна.

- ЗДТГазар- Шаардах хуудас гарын үсгийн бүрдэл дутуу, орлого, зарлагын баримт хүлээн авагч болон нягтлан гарын үсэг зураагүй зэрэг дотоод хяналт дээр анхаарах зөрчил илэрсэн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- Шилэн дансны цахим хуудаст 6.6 сая төгрөгийн 10 хөрөнгө зарцуулсан шийдвэрийг байршуулаагүй, 21 мэдээлэл хугацаа хоцроосон.
- ИТХ- Бичиг хэрэг, Аж ахуйн материал, Түлш, шатах тослох материалуудын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэнэ тайланг гаргаагүй, жолоочийн тооцооны хуудасны хөтлөлт хангалтгүй байна.
 - Дараах 2,200.0 мянган төгрөгийн гүйлгээний үндсэн баримт, төлбөрийн хүсэлт, тушаал шийдвэр нь харилцахын баримтад байхгүй байна. Тухайлбал:1. Бараа үйлчилгээний бусад зардлаас 1,850.0 мянга, 2. Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 350.0 мянга
 - Байгууллагын бүтцэд батлагдаагүй 1 орон тоо бий болгосноос болж ХХОАТ-ын 2036.2 мянган төгрөгийн өглөг үүссэн. Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.
 - Байгууллагын бүтцэд батлагдаагүй орон тоо болох бичиг хэргийн ажилтан ИТХ-ын төсвөөс цалинжуулж, 5,722.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
 - ИТХ-ын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардалд 10,500.0 мянган төгрөгийг зарцуулсан боловч 5,301.9 мянган төгрөг буюу 50.5 хувийг, бараа үйлчилгээний бусад зардал, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал зэргээс 4,251.8 мянган төгрөг нийт 9,553.7 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулжээ. Тухайлбал:
 - Хоол, хүнсний зардалд 5,432.7 мянга
 - Мөнгөн аяга бш 1,181.5 мянга
 - Домбо 225.0 мянга
 - Дурсгалын зүйл 928.0 мянга
 - Өндөр настанд хүндэтгэл үзүүлэхэд 200.0 мянга
 - Бичиг хэргийн зардалд 1,146.3 мянга
 - Волейболын бөмбөг 100.0 мянга
 - Уралдаан тэмцээний шагналд 340.0 мянган төгрөг
 - Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.2, 15.2.3 заалтуудыг зөрчин тээвэр шатахууны зардлыг зарцуулсан байна.
 - Шилэн дансны цахим хуудсанд таван саяас дээш дүнтэй орлогын 101.9 сая төгрөгийг илүү шивж оруулсан, зарлагын 17.3 сая төгрөгийн мэдээлэл болон хөрөнгө зарцуулах 13 тушаал шийдвэрийг байршуулаагүй байна.
- ОНХСан- Малын тоо толгойн албан татварын 2021, 2022 оны үлдэгдэл 27211.7 мянган төгрөгийг авлагаар бүртгүүлж залруулга хийгдсэн.
- Төрийн сан- Сумдын төсөвт байгууллагуудын дарга нарт ур чадварын нэмэгдэл олгохдоо ажлын үр дүнтэй уялдуулж хувь хэмжээг тогтоож, тухай бүр шийдвэр гаргаагүй, бүтэн жилээр тогтмол олгож ирсэн зөрчлүүд илэрсэн байна.
 - Баруунбаян-Улаан сумын цэцэрлэг нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон жилийн эцсийн санхүүгийн тайландаа Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цаглаварт хугацаанд аудит хийлгээгүй, хугацаа хоцорсон байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/сая төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн

Баруунбаян-Улаан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дүн													
-----	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Баруунбаян-Улаан ТТЗ	2	0					1	0				1	
Дүн	2						1					1	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Дүн									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн									

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 15-НИЙ ӨДӨР

